# МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР

## "ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГЫН" ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA) | 2023 он

ДЗКГ Д.Энхжин

www.sportarbitration.mn



## АГУУЛГА

I Танилцуулга, дүрмийн заалт, стандартын заалт ба тодорхойлолт

II Үр дүнгийн удирдлага — Ерөнхий зарчим

III Үр дүнгийн удирдлага — Шүүхийн шийдвэрийн өмнөх байдал

IV Үр дүнгийн удирдлага — Шүүхийн шийдвэр

V Хавсралтууд



# I

# ТАНИЛЦУУЛГА, ДҮРМИЙН ЗААЛТ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ЗААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ



**ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГА** гэдэг нь зөрчигдсөн допингийн эсрэг дүрмийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа юм.




- Дэлхийн Допингийн эсрэг дүрмийн хавсралт, заавал мөрдөх олон улсын стандартын нэг
- 11 бүлэг, 3 хавсралттай
- Шинжилгээний хариу хүлээн авахаас эхлэн давж заалдах хүртлэх бүх үе шатыг багтаасан
- Допингийн эсрэг байгууллагуудын үр дүнгийн удирдлагын ажиллагаатай холбоотой үндсэн үүргийг тодорхойлоход оршино.



## Стандартын зорилго ба хамрах хүрээ

**Зорилго:** Допингийн эсрэг байгууллагуудын үр дүнгийн удирдлагын ажиллагаатай холбоотой үндсэн үүргийг тодорхойлох

**Хамрах хүрээ:** Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан, заавал биелүүлэх олон улсын стандарт

### Үр дүнгийн удирдлагын үе шатууд:

Анхан шатны үзлэг → Мэдэгдэл → Түр түтгэлзүүлэлт → Хэрэг хянан шийдвэрлэх → Шийдвэр

### Дүрмийн холбогдох бүлгүүд:

- 2 дугаар бүлэг: Допингийн эсрэг дүрмийн зөрчил
- 3 дугаар бүлэг: Допингийн нотолгоо
- 5 дугаар бүлэг: Шинжилгээ ба мөрдөн шалгалт
- 7 дугаар бүлэг: Үр дүнгийн удирдлага
- 8 дугаар бүлэг: Шударгаар хянан хэлэлцэх эрх
- 9-р бүлэг - Хувийн амжилтыг автоматаар хүчингүй болгох
- 10-р бүлэг - Хувийн шийтгэл оногдуулах
- 11-р бүлэг - Багт учрах үр дагавар
- 13-р бүлэг - Үр дүнгийн удирдлага: давж заалдах
- 14-р бүлэг - Нууцлал ба мэдээлэл
- 15-р бүлэг - Шийдвэрийг хэрэгжүүлэх
- 20-р бүлэг - Гарын үсэг зурагчид ба ДДЭА-ийн нэмэлт үүрэг хариуцлага



## Гол нэр томъёоны тодорхойлолт

| Нэр томъёо | Тодорхойлолт |
|---|---|
| Сөрөг аналитик илэрц | Лабораториос гаргасан, шинжилгээний дээжинд хориглосон бодис илэрсэн тухай мэдэгдэл |
| Гаж илэрц | Сөрөг аналитик илэрцийг тогтоохоос өмнө гаргасан цаашдын судалгаанд шаардлагатай хариу |
| Допингийн эсрэг байгууллага | Допингийн хяналтын процессын аль нэг хэсгийг хэрэгжүүлэх үүрэгтэй гарын үсэг зурагчдыг хэлнэ |
| Тамирчин | Олон улсын болон үндэсний зэрэглэлийн уралдаан тэмцээнд оролцогч аливаа этгээд |
| Үр дүнгийн удирдлага | Мэдэгдлийн хоорондох хугацааг багтаасан, хэрэг эцэслэн шийдвэрлэх хүртэл бүх үйл явц |
| Хэрэг хянан шийдвэрлэх | Асуудлыг шүүх хуралдаанаар хэлэлцэж, шийдвэр гаргах, мэдэгдэх хүртэлх үйл явц |
| Үр дагавар | Хүчингүй болгох, эрх хасах, түр түтгэлзүүлэх, санхүүгийн шийтгэл, олон нийтэд мэдэгдэх |



# II

# ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГА — ЕРӨНХИЙ ЗАРЧИМ



# Нууцлал ба цаг хугацааны шаардлага

## 4.1 Үр дүнгийн удирдлагын нууцлал

- Мэдээлэх үйл явцыг нууцлалд хадгална
- Үр дүнгийн удирдлагатай холбоотой бүх үйл ажиллагааг нууцална
- Дүрмийн 14 дүгээр бүлгээр зохицуулна

## 4.2 Цаг хугацаа

- Зөрчлийг цаг тухайд нь шүүх шаардлагатай
- Мэдэгдлээс хойш **6 сарын дотор** үр дүнгийн удирдлагыг явуулах шаардлагатай
- Саатлаас сэргийлнэ

**Чухал:** 6 сарын хугацаа нь ноцтой ба давтан алдаа гаргасан тохиолдолд үр дагаврыг тооцох удирдамж.

**Зарчмын хувьд:** Спортын шударга, үр дүнтэй байдал, шударга ёсыг хангах зорилгоор допингийн эсрэг дүрмийн зөрчлийг аль болох хурдан шийдвэрлэх нь чухал. Допингийн эсрэг байгууллагууд саатлгүйгээр ажиллагаагаа явуулах шаардлагатай.



# III

# ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГА — ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ӨМНӨХ БАЙДАЛ



# Сөрөг аналитик илэрц — Эхний хянан үзлэг

Үр дүнгийн удирдлагын эрх бүхий байгууллага сөрөг аналитик илэрцийг хүлээн авсны дараа дараах 3 зүйлийг шалгана:

**а Эмчилгээний зорилгоор чөлөөлөх**

ADAMS системд эмчилгээний зорилгоор чөлөөлөх батламж байгаа эсэхийг шалгана

**б Стандартаас гажсан эсэх**

"Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандарт", эсвэл "Лабораторийн" олон улсын стандартаас гажсан эсэх

**в Зөвшөөрөгдсөн замаар илэрсэн**

Хориглосон бодис зөвшөөрөгдсөн замаар биед орсон эсэх

## Гаж илэрцийн хувьд:

- Гаж илэрц гарсан үед дээрх 3 шалгалтыг ижилхэн гүйцэтгэнэ
- Чөлөөлөх зөвшөөрөл байгаа, стандартаас гажсан, зөвшөөрөгдсөн замаар орсон нь **тогтоогдоогүй** бол мөрдөн шалгалт явуулна
- Мөрдөн шалгалт дууссаны дараа гаж илэрцийг сөрөг илэрц гэж үзэн 5.1 зүйлийг дагаж мөрдөнө

**МЭДЭГДЭЛ**

- Допингийн эсрэг дүрмийн зөрчил гэж үзэхгүй
- Үр дүнгийн удирдлагын ажиллагааг үргэлжлүүлэхгүй



# Мэдэгдэл хийх үйл явц

### Мэдэгдэлд багтах зүйлс:

- Сөрөг аналитик илэрц
- Дүрмийн зөрчил (2.1 эсвэл 2.2)
- "Б" сорьцыг шинжлүүлэх эрх, хүсэлт гаргаагүй бол татгазсан
- Тамирчин, төлөөлөгч нь Лабораторын ОУС-ын дагуу “Б” сорьцыг задлах, шинжлэх
- "А" сорьцын бичиг баримтын хуулбар авах эрх

### Тамирчид олгох боломж:

- Тайлбар өгөх
- 10.7.1 Бодит туслалцаа үзүүлэх
- 10.8.1 Эрх хасах хугацааг 1 жилээр бууруулах
- 10.8.2 Хэрэг хянан шийдвэолэх гэрээ байгуулах
- 6-р бүлэг Түр түтгэлзүүлэлтийг сайн дураар хүлээн зөвшөөрөх

### Тусгай тохиолдлууд:

- **Сальбутамол, Формотерол:** Эмчилгээний тунгаар хэрэглэсэнээс шалтгаалсан эсэхийг нотлох боломжтой
- **hCG, LH:** Эрэгтэй тамирчдын шээсэнд илэрсэн тохиолдолд удирдан зохиойн байгуулах техникийн баримтаар удирдана
- **"Б" сорьц:** "А" сорьцын хариуг баталсан тохиолдолд тайлбар өгөх хугацаа олгоно



# Түр түтгэлзүүлэлт ба хариуцлага

## 6.0 Түр түтгэлзүүлэлт

**Зарчим:** Хэрэг хянан шийдвэрлэх эцсийн шийдвэр гарах хүртэл тамирчны тэмцээн уралдаанд оролцох эрхийг түр хориглоно. Тэмцээний үр дүн хүчингүй.

**Албан журмын түр түтгэлзүүлэлт:**

- Тусгайлсан бодис, аргаас бусад хориглосон бодистой холбоотой сөрөг илэрц гарсан үед
- 7.2 Мэдэгдэл хийх үед эсвэл дараа нь нэн даруй онооно
- **Албан журмын бус түр түтгэлзүүлэлт:**
- 7.4.1 т зааснаас бусад тохиолдолд нотлох баримтыг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэр гарахаас өмнө

**Сайн дурын түр түтгэлзүүлэлт:**

- "Б" дээжийн хариу мэдэгдсэнээс хойш 10 хоногт
- Татгалзаж болох, хөнгөлөлт олгохгүй

## 7.0 Хариуцлага

**Дүрэм зөгчсөн гэж үзвэл нэн даруй мэдэгдэнэ.**

**Хариуцлын мэдэгдэлд:**

- Зөрчсөн гэж үзсэн дүрмийн заалт
- Нотлох баримт, хураангүй /шинэ/
- Оноох үр дагавар
- Үр дагаврыг хүлээн зөвшөөрөх эсвэл эсэргүүцэх 20 хоног

**Хүлээн зөвшөөрвөл:**

- 9 дүгээр бүлгийн дагуу шийдвэрийг нэн даруй гаргаж, мэдэгдэнэ
- Туслалцаа үзүүлсэн бол эрх хасах хугацааг 1 жилээр бууруулж болно

Түр түтгэлзүүлэх хугацаа өмнө нь цуцлаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх хуралдааны эцсийн шийдвэр гарснаар дуусгавар болно. Эрх хасах хугацааны дээд хязгаараас хэтэрч болохгүй.



# IV

## ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГА — ШҮҮХИЙН ШИЙДВЭР



# Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

## 8.0 Хэрэг хянан шийдвэрлэхийн үндсэн зарчмууд:

- Шударга, ялгаварлалгүй, хараат бус
- Хүртээмжтэй, хямд байх
- Биечлэн биш, цахимаар явуулж болно
- Боломжит цаг хугацаанд явуулах

### Хэрэг хянан шийдвэрлэх комисс

- Хэрэг хянан шийдвэрлэх комисст хянан шийдвэрлэх эрх олгох зохицуулалтыг тусгана
- Биечлэн хийхийг шаардахгүй
- Технологи ашиглан цахимаар явуулж болно
- Видео хурал хийх боломжтой

### Тамирчны эрхүүд:

- Өмгөөлөгч авах эрх
- Нотлох баримт бичгээр болон амаар өгөх эрх
- Гэрчийг дуудах, мэдүүлэг авах эрх
- Хэлмэрч оролцуулах эрх
- Хуралдааныг нээлттэй хийлгэх хүсэлт гаргах эрх

### Комиссын бүрэлдэхүүн:

- Хууль, спорт, анагаах ухааны мэдлэгтэй гишүүд
- Хамгийн багадаа **2 жилийн** хугацаагаар томилно
- Хамгийн багадаа 1 гишүүн хууль, эрх зүйн боловсролтой
- Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэгээр баталгаажуулна

**Тэмдэглэл:** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдавчилсан хэлбэрээр явуулж болно. Бүх шийдвэрийг талууд бичгээр материалаа ирүүлсний дараа нэн даруй гаргаж, мэдэгдэнэ.



# 8.0 ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ (II)

## 8.3 Хараат бус этгээд

- Холбогдох дүрмээр хараат бус этгээдийг шийдвэрлэх боломжоор хангана
- Багадаа нэг гишүүн хууль, эрх зүйн боловсролтой байх

## 8.4 Мэдүүлэг

- Гишүүн бүр мэдүүлэгт гарын үсэг зурна
- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ батална
- Зөрчил үүсвэл 7 хоногийн дотор мэдээлэх

## 8.5 Талуудад мэдэгдэх

- Талуудад мэдэгдэнэ
- Ашиг сонирхлын зөрчил үүсгэсэнийг мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор мэдээлэх эрхтэйг мэдэгдэнэ.

## 8.6-8.7 нэмэлт заалтууд:

- **8.6** Үйл ажиллагааны хараат бус байдлыг журмаар баталгаажуулна
- **8.7** Хангалттай нөөцийг бүрдүүлнэ (хууль зүйн, санхүүгийн, техникийн)

Хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь допингийн эсрэг байгууллагаас хараат бус байх ёстой. Энэ нь шударга шийдвэр гаргах үндсэн нөхцөл юм.

# 8.8 ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМУУД

| № | Зарчим | Тайлбар |
|---|---|---|
| а) | Шударга, ялгаварлалгүй, хараат бус | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шударга, ялгаварлалгүй, хараат бус байх |
| б) | Хүртээмжтэй, хямд | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүртээмжтэй, хямд байх |
| в) | Боломжит цаг хугацаанд | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боломжит цаг хугацаанд явуулна |
| г) | Шударгаар мэдээлэх эрх | Тамирчинд шударгаар мэдээлэх эрх, өмгөөлөгч авах эрх, нотлох баримт өгөх эрх, гэрч дуудах эрх |
| д) | Олон нийтэд нээлттэй | Олон нийтэд нээлттэй хийлгэх хүсэлт гаргах эрхтэй |
| 8.9 | Хурдавчилсан хэлбэр | Хурдавчилсан хэлбэрээр явуулж болно (тамирчин зөвшөөрсөн тохиолдолд) |



## Шийдвэр

### 9.0 Шийдвэр

9.1.1 Шийдвэрт заавал тусгагдах зүйлс:

- Хууль зүйн үндэслэл ба холбогдох дүрмүүд, ОУ стд
- Баримтын дэлгэрэнгүй мэдээлэл
- Зөрчигдсөн допингийн эсрэг дүрэм
- Холбогдох үр дагавар
- Давж заалдах зам ба эцсийн хугацаа

### 9.1.2

Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдын шийдвэр хязгаарлагдмал байж болох бөгөөд багадаа: зөрчсөн тухай бодит үндэслэл, дүрмийн зөрчигдсөн зүйл, холбогдох үр дүнг хүчингүй болгох, медаль/шагналыг хураахыг тусгасан байна.

**Мэдэгдэл:** Шийдвэрийг нэн даруй мэдэгдэж, ADAMS-д оруулна. Шийдвэр нь англи эсвэл франц хэлээр гараагүй бол шалтгаан бүхий товч тайлбарыг англи/францаар үйлдэнэ.



# 9.0 ШИЙДВЭР (II) - Мэдэгдэл

**9.2: Шийдвэрийг нэн даруй мэдэгдэж, ADAMS-т оруулна.**

**9.2.1:** Эрх хасуулсан хугацаанд тэмцээнэд оролцох зөрчлийн талаар мэдэгдэнэ

**9.2.2:** Шинжилгээнд хамрагдах үүрэгтэй тухай мэдэгдэнэ

**9.2.3:** Хавтаст хэргийн хуулбарыг шаардсан тохиолдолд нэн даруй гаргаж өгнө.

**9.2.4:** Шийдвэрийг давж заалдах хугацаа өнгөрсөн, эсвэл гомдол гаргаагүй бол лабораторид эцэслэн шийдвэрлэсэн тухай мэдэгдэнэ.

- Шийдвэр гарснаас хойш 21 хоногийн дотор давж заалдах эрхтэй
- Шийдвэрийг бүх холбогдох этгээдүүдэд мэдэгдэнэ
- ADAMS-д шийдвэрийг шуурхай оруулна



# Давж заалдах

## 10.0 Давж заалдах

### Давж заалдах эрх:

- Дүрмийн 13 дугаар бүлгээр зохицуулна
- Үндэсний хэмжээнд давж заалдах
- САШ-д гомдол гаргах

### Үндэсний хэмжээнд:

- Давж заалдах шатны бүрэлдэхүүн шударга, хараат бус байна
- Шийдвэр нь 9.1 зүйлд заасан шаардлагад нийцсэн байх

### САШ-д:

- Спортын арбитрын дүрмээр зохицуулна
- Бүх талууд цаг тухайд мэдэгдэх үүрэгтэй
- ДДЭА-ийн зөвшөөрөлгүйгээр төлбөр хийхийг хориглоно

**Мэдэгдэл:** Шийдвэрийг нэн даруй мэдэгдэж, ADAMS-д оруулна. Шийдвэр нь англи эсвэл франц хэлээр гараагүй бол шалтгаан бүхий товч тайлбарыг англи/францаар үйлдэнэ.



# 10.0 ДАВЖ ЗААЛДАХ

## Давж заалдах шатны шаардлага:

- Давж заалдах шатны шийдвэр нь анхан шатны шийдвэрийг батална болно, эсвэл өөрчилж болно
- Давж заалдах шатны шийдвэр нь эцсийн шийдвэр бөгөөд дахин давж заалдах боломжгүй (САШ-ээс бусад)
- САШ-ийн шийдвэр нь олон улсын түвшинд эцсийн шийдвэр юм
- Давж заалдах ажиллагаа нь шударга, хараат бус, ил тод байх ёстой



# V

# ХАВСРАЛТУУД



# Байршлын мэдээллийн алдаа ба биологийн паспорт

## Хавсралт Б — Байршлын мэдээллийн алдаа

**12 сарын хугацаанд 3 удаагийн алдаа = дүрмийн 2.4 зүйлийн зөрчил**

Алдааны төрлүүд:

- **Мэдээллээ өгөөгүй:** Байршлын мэдээллээ бүрэн өгөөгүй
- **Шинжилгээ өгөөгүй:** 60 минутын хугацаанд шинжилгээ өгөөгүй

Үр дагавар: Эрх хасах + амжилтыг хүчингүй болгох

## Хавсралт С — Биологийн паспорт

**Үйл явцын алхмууд:**

1. Дасан зохицох загвараар автомат хянан үзэг
2. Шинжээчийн анхан шатны үнэлгээ
3. 3 шинжээчийн зөвлөлийн хянан үзлэг
4. "Допинг байх магадлалтай" дүгнэлт
5. Баримт бичгийн багц бүрдүүлэх
6. Тамирчинд мэдэгдэх, тайлбар авах

**Тэмдэглэл:** Биологийн паспорт нь хориглосон бодис/аргын боломжит хэрэглээг илрүүлэх хэрэгсэл бөгөөд энэ нь эрүүл мэндийн үзлэг, эмнэлгийн хяналтанд зориулагдаагүй болно.



# Үндэсний түвшинд
# Үр дүнгийн удирдлага хариуцах

NATIONAL ANTI-DOPING ORGANIZATIONS

## Үндэсний допингийн эсрэг байгууллага

Шинжилгээний хариуг хүлээн авахаас

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хүртэл



## хэрэг хянан шийдвэрлэх комисс

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах



## Давж заалдах комисс

Давж заалдах шатны ажиллагаа

Шаардлагатай бол анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

## МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР




www.sportarbitration.mn



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Монголын Олон Улсын ба Үндэсний Спортын Арбитр